



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 27 (600)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Зарим нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох тухай*
- *Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойн медаль бий болгох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэсгэл

2009 оны долдугаар сарын 24 № 27 (600)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|---|-----|
| 359. | Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 612 |
| 360. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 612 |
| 361. | Зарим нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох тухай | 612 |
| 362. | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 613 |
| 363. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 614 |
| 364. | Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 614 |
| 365. | Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 614 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 366. | Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 49 | 620 |
| 367. | Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойн медаль бий болгох тухай | Дугаар 50 | 620 |
| 368. | Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай | Дугаар 51 | 621 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|--|------------|-----|
| 369. | Өвөрхангай аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 131 | 622 |
| 370. | Өмнөговь аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 132 | 623 |
| 371. | Сүхбаатар аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 133 | 624 |
| 372. | Сэлэнгэ аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 134 | 624 |
| 373. | Төв аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 135 | 626 |
| 374. | Увс аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 136 | 627 |
| 375. | Ховд аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 137 | 629 |
| 376. | Хөвсгөл аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 138 | 631 |
| 377. | Хэнтий аймгийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 139 | 633 |
| 378. | Нийслэлийн харьяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай | Дугаар 140 | 633 |

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 379. | Барилга захиалагчийн дүрэм батлах тухай | Дугаар 73 | 637 |
| 380. | Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлах тухай | Дугаар 74 | 638 |



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.1.3. төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн улсын төсвийг батлах."

2 дугаар зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн гэрчгийг "Улсын Их Хуралд төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг өргөн

мэдүүлэх, хэлэлцэх" гэж, мөн зүйлийн 25.1, 25.3 дахь хэсгийн "мэдэгдлийг" гэснийг "мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "баталсан" гэсний дараа "Үндсэн чиглэл," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шинэчлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар,

үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдэл, дараа жилийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /цаашид "Үндсэн чиглэл" гэх/-ийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ."

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАРИМ НИЙЛЭГ ХАЛЬСАН УУТНЫ ХЭРЭГЛЭЭГ ХОРИГЛОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт 0.025 мм болон түүнээс бага зузаантай нийлэг хальсан уутыг хүнсний бүтээгдэхүүнд багтаа бодлын зориулалтаар импортлох, хэрэглэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Зарим нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Байгаль орчныг хамгаалах тухай², Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай³,

энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "нийлэг хальсан уут" гэж багтаа боодолд хэрэглэх зориулалтаар химийн нийлэгжүүлэлтийн аргаар үйлдвэрлэсэн, дахин боловсруулах боломжгүй, удаан задардаг уутыг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль - Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1995 оны 101 дүгээрт нийтлэгдсэн.

³ Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль - Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2003 оны 47 дугаарт нийтлэгдсэн.

3.1.2. "баглаа боодол" гэж түүхий болон хагас боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнийг ороох, савлах зориулалттай нэг удаагийн хэрэглээний нийлэг хальсыг.

4 дүгээр зүйл. Нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох

4.1. Бүх төрлийн 0.025 мм болон түүнээс бага зузаантай нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд баглаа боодлын зориулалтаар хэрэглэхийг хориглоно.

4.2. Энэ хуулийн 4.1-д заасан зориулалтаар нийлэг хальсан уутыг импортлохыг хориглоно.

5 дугаар зүйл. Хуулийн биелэлтэд тавих хяналт

5.1. Зарим нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох тухай хуулийн биелэлтэд тавих хяналт нь төрийн болон олон нийтийн гэсэн хэлбэртэй байна.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасан төрийн хяналтыг бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон мэргэжлийн хяналтын байгууллага, албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

5.3. Энэ хуулийн 5.1-д заасан олон нийтийн хяналтыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг

төрийн бус байгууллага, иргэн хэрэгжүүлж болно.

6 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

6.1. Зарим нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч захиргааны дараахь шийтгэл ногдуулна:

6.1.1. энэ хуулийн 4.1-д заасныг зөрчсөн иргэнийг 30000-50000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 150000-200000 төгрөгөөр торгох;

6.1.2. энэ хуулийн 4.2-т заасныг зөрчсөн бол импортлосон зүйлийг хурааж, иргэнийг 100000-150000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 250000-350000 төгрөгөөр торгох.

7 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

7.1. Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 32.1.3 дахь заалт нэмсүгэй:

"32.1.3. энэ хуулийн 32.1.2-т заасны дагуу Байнгын хороод Цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулна."

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтын "санал, дүгнэлт гаргана" гэсний өмнө "бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь /хэсэгчлэн/ хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаар" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32

дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтын дугаарыг "32.1.4" болгон өөрчилж, мөн заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"32.1.4. нэгдсэн хуралдаан Цэцийн дүгнэлт, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонссоны дараа энэ хуулийн 32.1.3-т заасны дагуу Байнгын хорооноос гаргасан санал тус бүрээр ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар тогтоол батлах бөгөөд уг тогтоолд зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн заалтыг тус тусад нь заана."

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7 дахь заалтын "32.1.5-д" гэснийг "32.1.6-д" гэж, мөн зүйлийн 32.1.4-32.1.9 дэх заалтын дугаарыг "32.1.5-32.1.10" болгон тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/54 дүгээр зүйлийн 54.4.2 дахь заалт:

"54.4.2. нөхөн сонгуульд оролцох, нам, эвслийг тухайн сонгууль зарласнаас хойш 5 хоногийн дотор бүртгэх;"

2/54 дүгээр зүйлийн 54.4.7 дахь заалт:

"54.4.7. нөхөн сонгууль эхлүүлэхээр төвлөн зарласан өдрөөс хойш 30 хоногийн дотор санал хураалт явуулна."

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/54 дүгээр зүйлийн 54.2, 54.3 дахь хэсэг:

"54.2. Энэ хуулийн 54.1-д заасан шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн орон гарсан бол ийнхүү орон гарснаас хойш 30 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороо нөхөн сонгууль явуулах талаархи саналыг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурал уг саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор нөхөн сонгуулийг төвлөн зарлах

асуудлыг шийдвэрлэж, ийнхүү шийдвэр гаргаснаас хойш 90 хоногийн дотор сонгууль явуулж дууссан байхаар тогтооно.

54.3. Нөхөн сонгуулийг төвлөн зарлах өдөр нь чуулганы чөлөө цагт тохиовол Улсын Их Хурал ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 14 хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэнэ."

2/54 дүгээр зүйлийн 54.4.1 дэх заалт:

"54.4.1. хэсгийг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө, тойргийн хороог 20-иос доошгүй хоногийн өмнө, салбар болон хэсгийн хороог 15-аас доошгүй хоногийн өмнө тус тус байгуулах;"

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.2-54.4.5 дахь заалтын дугаарыг "54.4.3-54.4.6" болгон өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 10 дахь заалтын "хэрхэн шийдвэрлэсэн тухай" гэсний дараа "буюу энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан

хууль, шийдвэрийн Үндсэн хууль зөрчсөн гэх заалт тус бүрээр, Үндсэн хуулийн зөрчигдсөн заалт бүрийг" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2009 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "тус тус" гэсний өмнө, авто зам, барилга, эрчим хүчний салбарт 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтөөр нэмэгдсэн зардлын хэмжээг 12,866.8 сая төгрөгөөр гэж, 5 дугаар зүйлийн "2 дугаар хавсралтаар" гэсний дараа, "Авто зам, барилга, эрчим хүчний салбарт

2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтөөр нэмэгдсэн зардлын жагсаалт"-ыг 3 дугаар хавсралтаар" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"Монгол Улсыг хөгжүүлэх сангийн
2009 оны төсвийн тухай хуулийн
1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГӨӨР
САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

(Төсвийн ерөнхийлөн захирагчаар, сая.төг/)

Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил		Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2009 оны санхүүжилт
I	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА		577.3	577.3
I.1	Тоног төхөөрөмж	2009	577.3	577.3
II	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД		17,255.0	3,300.0
II.1	Чөлөөт бүс		15,755.0	1,800.0
II.1.1	"Замын-Үүд" чөлөөт бүсийн мэргэжлийн албадын нэгдсэн байр /Дорноговь, Замын-Үүд/	2008-2009	1,000.0	800.0
II.1.2	"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн хорооллын доторхи зам, хэсэгчилсэн хөрөнгө оруулалт /Сэлэнгэ, Алтанбулаг/	2009-2011	14,755.0	1,000.0
II.2	Үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалт	2009	1,500.0	1,500.0
III	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД		1,500.0	1,500.0
III.1	Бүсчилсэн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт	2009	1,500.0	1,500.0
IV	САНГИЙН САЙД		2,000.0	2,000.0
IV.1	Бүс, орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалт	2009	2,000.0	2,000.0
V	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД		39,945.4	28,520.3
V.1	Цахилгаан дамжуулах шугам, дэд станц:		12,709.9	12,709.9
V.1.1	Ил хуваарилах байгууламж-4-д 220/110/35 кВ-ын 125 мВа чадалтай автотрансформатор суурилуулах /Улаанбаатар/	2009	2,754.9	2,754.9
V.1.2	Умард дэд станцын трансформатор, хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/	2009	3,150.0	3,150.0
V.1.3	6, 10 кВ-ын дэд станцуудын тосон таслууруудыг вакуум болгох /РП 3,5, 6, 13, 24/ Улаанбаатар/	2009	1,080.0	1,080.0
V.1.4	Дархан хотын 220/110/35 кВ-ын дэд станц, 35 кВ-ын реактор суурилуулах /Дархан-Уул/	2009	1,827.0	1,827.0
V.1.5	Могойн гол дээр цахилгааны эх үүсвэр барих техник, эдийн засгийн үндэслэл, Тэлмэн-Могойн голын цахилгаан дамжуулах шугам, дэд станц /Завхан, Хөвсгөл/	2009	3,800.0	3,800.0
V.1.6	Тэс-Зүүнхангайн 38 км ЦДАШ-ыг шилжүүлэх/Завхан/	2009	98.0	98.0
V.2	Дулааны станц, дулааны шугам сүлжээ, нүүрсний уурхай:		23,885.5	15,310.4
V.2.1	Дулааны сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулахад насос станц №1, 6-ын хүчин чадлыг нэмэгдүүлж шинэчлэх /Улаанбаатар/	2009	1,776.1	1,776.1
V.2.2	Дулааны 5 "б" магистраль 1950м*2, 500 мм-ийн шугамыг 800 мм болгон өргөтгөж шинэчлэх /Улаанбаатар/	2009	3,816.0	3,816.0
V.2.3	Дулааны 6 "б", "в" магистраль 2198м*2, 500 мм-ийн шугамыг 600 мм болгон өргөтгөж шинэчлэх /Улаанбаатар/	2009	4,657.5	4,657.5
V.2.4	Дулаан хангамжийн системийг хаалттай системд шилжүүлэх /Дархан-Уул/	2009-2010	1,350.0	720.0
V.2.5	Багануурын нүүрсний уурхайн техникийн шинэчлэлт	2009-2010	12,285.9	4,340.8



Y.3	Эрдэс баялаг:		3,350.0	500.0
Y.3.1	Хөрөнгө оруулалт: Газрын тосны чанарын хяналтын лаборатори байгуулах	2008-2010	3,350.0	500.0
YI	ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД		138,280.9	66,567.0
YI.1	Авто зам:		54,790.8	16,587.8
YI.1.1	Өгийнуур-Хөшөөцайдам чиглэлийн 10 км хатуу хучилттай авто зам	2007-2009	1,298.9	280.1
YI.1.2	Хархорин-Цэцэрлэгийн 74 км хайрган авто замыг хатуу хучилттай болгох	2007-2009	8,403.6	1,955.8
YI.1.3	Цэцэрлэг-Их тамир-Тосонцэнгэл чиглэлийн 53 км хайрган авто замыг хатуу хучилттай болгох	2007-2009	8,296.0	1,528.2
YI.1.4	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 109 км хатуу хучилттай авто зам	2007-2009	19,073.9	8,663.3
YI.1.5	Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 30.4 км хайрган авто зам	2007-2009	3,040.0	221.8
YI.1.6	Хархорин-Хужиртын 39 км хатуу хучилттай авто зам	2006-2009	5,841.2	1,002.2
YI.1.7	Дамдинсүрэнгийн гудамжны авто зам /Улаанбаатар/	2006-2009	1,800.0	104.3
YI.1.8	Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн 14.5 км хатуу хучилттай авто зам	2008-2009	3,045.0	1,045.0
YI.1.9	Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 23 км хайрган авто замыг хатуу хучилттай болгох	2007-2009	2,992.2	787.1
YI.1.10	Баруун чиглэлийн 600 км авто замын зураг боловсруулах/Баянхонгор, Алтай, Ховд, Завхан/	2009	1,000.0	1,000.0
YI.2	Гүүр:		15,063.9	9,736.8
YI.2.1	Эгийн голын 160 у/м төмөр бетон гүүр /Хөвсгөл, Түнэл/	2007-2009	1,812.5	1,532.5
YI.2.2	Турганы голын 96.9 у/м төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Саргай/	2008-2009	999.0	799.0
YI.2.3	Туул голын Горхийн 211 у/м төмөр бетон гүүр /Улаанбаатар, Тэрэлж/	2007-2009	2,422.5	829.5
YI.2.4	Хөвд голын 181.8 у/м төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус/	2008-2009	1,500.0	1,080.9
YI.2.5	Нарийний голын 325 у/м төмөр бетон гүүр /Увс, Тэс/	2006-2009	2,750.0	1,815.0
YI.2.6	Их тэнгэрийн 258 у/м төмөр бетон гүүр /Улаанбаатар/	2007-2009	3,986.5	2,286.5
YI.2.7	Идэрийн голын төмөр бетон гүүр /Завхан, Их-Уул/	2008-2009	1,593.4	1,393.4
YI.3	Иргэний нисэхийн ерөнхий газар:		44,794.2	16,610.4
YI.3.1	Хөрөнгө оруулалт:		25,884.0	8,000.0
YI.3.1.1	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвасын хүчитгэлийн ажил, гэрлэн тэмдэгт /Улаанбаатар, "Чингис хаан" Олон улсын нисэх онгоцны буудал /	2008-2011	7,000.0	1,500.0
YI.3.1.2	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Гоёв-Алтай/	2008-2010	7,385.3	2,300.0
YI.3.1.3	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Увс/	2008-2010	11,498.7	4,200.0
YI.3.2	Тоног төхөөрөмж: Бодит ажиглалтын систем /радиолокатор 3ш, VOR/DME 4ш/	2008-2009	18,910.2	8,610.4
YI.4	Тээвэр		23,632.0	23,632.0
YI.4.1	Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлт /Их багтаамжтай автобус, 400 ш/	2009	23,632.0	23,632.0
YII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД		30,300.0	30,300.0
YII.1	Хөрөнгө оруулалт: "Атрын 3 дахь аян" газар тариалангийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2009	30,300.0	30,300.0



ҮШ	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД		2,800.0	1,145.0
ҮШ.1	ШУТИС-ын номын өргөөний барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2007-2009	2,800.0	1,145.0
IX	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД		21,134.7	21,134.7
IX.1	Ахмад дайчдад олгох орон сууцны дэмжлэг	2009	21,134.7	21,134.7
X	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД		500.0	500.0
X.1	Спорт цогцолборын барилга барих /Хөвсгөл, Мөрөн/	2009	500.0	500.0
XI	НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА		11,090.0	11,090.0
XI.1	Туул гол дээрх Баянзүрхийн 252.6 у/м төмөр бетон гүүрийн шинэчлэлт /Улаанбаатар, Баянзүрх/	2009	920.0	920.0
XI.2	Гурвалжингийн 108 у/м, 2 хос гүүрний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2009	2,080.0	2,080.0
XI.3	Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгах	2009	90.0	90.0
XI.4	Эрчим хүчинд холбогдоогүй нийслэлийн 7000 өрхийн гэрлийн асуудлыг шийдвэрлэх /Улаанбаатар/	2009	4,000.0	4,000.0
XI.5	Сонгинохайрхан дүүргийн 7000 өрхийн гэрлийн асуудлыг шийдвэрлэх /Улаанбаатар/	2009	4,000.0	4,000.0
	НИЙТ ДҮН		265,383.3	166,634.3

3 дугаар зүйл. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн "51,282.2" гэснийг "132,923.4" гэж, 4 дүгээр зүйлийн "122,289.3" гэснийг "179,501.1" гэж, "57,184.5" гэснийг "104,600.0" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан эдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

"Монгол Улсыг хөгжүүлэх сангийн
2009 оны төсвийн тухай хуулийн
3 дугаар хавсралт

**АВТО ЗАМ, БАРИЛГА, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ
2008 ОНД ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНИЙН ӨСӨЛТӨӨР НЭМЭГДСЭН
ЗАРДЛЫН ЖАГСААЛТ**

/Төсвийн ерөнхийлөн захирагчаар, сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр хүч, чадал, байршил	Үнийн зөрүү
	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	1,115.3
1	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Архангай, Булган/	6.5
2	Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал /Архангай, Цэцэрлэг/	7.9
3	Соёлын төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан/	6.9
4	Сургуулийн спорт заалны өргөтгөл /Баянхонгор, Богд/	2.1
5	Соёлын төвийн дуусгал /Баянхонгор, Бөмбөгөр/	2.3
6	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баянхонгор, Баянцагаан/	50.8
7	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Баян-Өндөр/	48.1
8	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Баян-Уул/	21.0
9	Соёлын төвийн барилга, 150 суудал /Говь-Алтай, Дэлгэр/	7.6
10	"Алтай" чуулгын байр /Говь-Алтай/	149.1
11	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр/	3.9
12	Хүүхдийн цэцэрлэг-яслийн цогцолбор, 100 ор /Говьсүмбэр, Сүмбэр/	23.0
13	Цэцэрлэгийн барилгын дуусгал /Завхан, Отгон/	11.2
14	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Тэс/	1.4
15	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга /Завхан /	14.1
16	Сургуулийн спорт заалны барилга, 3 дугаар сургууль /Дорноговь/	16.4

17	Сургуулийн дотуур байрны барилга /Дорнод, Чойбалсан/	70.7
18	Соёлын төвийн барилга /Дорнод, Сэргэлэн/	14.0
19	Сургуулийн дотуур байрны барилга, 80 ор / Дундговь, Сайнцагаан /	17.0
20	Соёлын төвийн барилга /Дундговь, Хулд/	21.8
21	Сургуулийн барилга /Төв, Жаргалантын Талбулаг/	11.6
22	Сургуулийн өргөтгөл, спорт заал /Төв, Батсүмбэр/	8.5
23	5 дугаар сургуулийн өргөтгөл /Төв, Зуунмод/	10.4
24	Соёлын төвийн барилга /Өвөрхангай, Нарийнтээл/	13.8
25	Цэцэрлэгийн барилга, 75 ор / Өвөрхангай, Бүрд /	3.9
26	Сургууль, 640 суудал, спорт заал, /Увс, Улаангом/	112.3
27	Сургуулийн спорт заал, 4 дүгээр сургууль /Увс/	11.8
28	Коллежийн барилгын шинэчлэл /Увс, Улаангом/	39.1
29	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Увс, Баруунтуруун/	7.7
30	Соёлын төвийн барилга /Увс, Хяргас/	17.9
31	Соёлын төвийн барилга /Увс, Ховд/	18.6
32	Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Ханх/	36.8
33	2 дугаар цэцэрлэгийн Б корпусын барилгын өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн/	8.0
34	Сургуулийн барилгын өргөтгөл, 10 анги, спорт заал /Хэнтий, Өмнөдэлгэр/	21.8
35	Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий,Норовлин /	5.6
36	Соёлын төвийн барилга /Хэнтий, Баян-Овоо/	8.0
37	Сургууль, дотуур байрны өргөтгөл /Хэнтий, Бор-Өндөр/	19.5
38	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Хэнтий, Баян-Адрага/	13.3
39	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/	124.0
40	Цэцэрлэгийн барилга, 100 ор, /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/	50.0
41	38-р цэцэрлэгийн барилгын дуусгал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	11.9
42	ХААИС-ийн оюутны дотуур байрны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	64.8
	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	647.9
1	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын конторын барилга	176.8
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 1000 хүний багтаамжтай жишиг цагдан хорих байр	301.1
3	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн конторын барилга	170.0
	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	128.4
1	Дүүргийн шүүхийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	102.4
2	Дүүргийн шүүхийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	26.1
	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	633.6
	Цэргийн албан хаагчдын 126 айлын орон сууцны барилга, Зэвсэгт хүчний 089 дүгээр анги /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	268.1
1	Цэргийн албан хаагчдын 50 айлын орон сууц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	198.9
2	Батлан хамгаалахын их сургуулийн оюутны дотуур байр /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	113.8
3	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн цэргийн албан хаагчдын 24 айлын орон сууц /Өмнөговь/	52.8
	САНГИЙН САЙД	1,244.6
1	Татварын ерөнхий газрын конторын барилга	353.4
2	Сангийн яамны төрийн сан, мэдээллийн төвийн барилга	391.4
3	Ажилчдын 60 айлын орон сууцны барилга /Улаанбаатар/	408.5
4	Татварын хэлтсийн барилга /Булган/	26.7
5	Гаалийн ерөнхий газрын албан конторын барилга /Улаанбаатар/	64.7
	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	941.6
1	Тэлмэн-Тосонцэнгэл сумын 35 кВ-ын ЦДАШ, дэд станц, /Завхан/	53.0
2	БНХАУ-ын Зүүн хатавч боомт-Эрдэнэцагаан сумын 35 кВ-ын ЦДАШ, дэд станц /Сүхбаатар/	15.1
3	Баяндун-Баян-Уул сумын 35 кВ-ын ЦДАШ, дэд станц /Дорнод/	124.4
4	Асгат-Баянхайрхан сумын 15 кВ-ын ЦДАШ, дэд станц, /Завхан/	8.6
5	Түдэвтэй-Цэцэн-Уул сумын 35 кВ-ын ЦДАШ, дэд станц, /Завхан/	86.7
6	Шарга-Төгрөг сумын 35 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	67.5
7	Тайшир-Улиастай 110кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/	71.6
8	Бөмбөгөр-Заг сумын 35 кВ-ын ЦДАШ, дэд станц, /Баянхонгор/	124.8

9	Алаг-Эрдэнэ-Улаан-Уул-Рэнчинлхүмбэ-Цагааннуур 35кВ-ын ЦДАШ, дэд станц /Хөвсгөл/	283.5
10	Тариалан-Эрдэнэбулган сумын 15 кВ-ын ЦДАШ, дэд станц /Хөвсгөл/	31.4
11	Хайлааст 110 кВ-ын ЦДАШ, 10/35/10 кВ-ын дэд станц /Улаанбаатар/	75.1
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА		1,476.9
1	Бохир усны "Туул-1" коллектор	1,301.5
2	Улаанбаатар хотын төвийн болон хойд хэсгийн хөрсний ус зайлуулах барилга байгууламж	175.5
ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД		5,726.0
Авто зам:		3,503.5
1	Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн 14.5 км хатуу хучилттай авто зам	173.6
2	Баянхонгор-Нарийнтээлийн 50 км хатуу хучилттай авто зам	229.0
3	Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 30.4 км хайрган авто зам	156.9
4	Хархорин-Хужирт чиглэлийн 39 км хатуу хучилттай авто зам	60.0
5	Хархорин-Цэцэрлэгийн 46.8 км хайрган авто замыг хатуу хучилттай болгох	124.6
6	Улаангом-Тээлийн 15 км хатуу хучилттай авто зам	82.6
7	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам	202.1
8	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн 20 км хатуу хучилттай авто зам	46.2
9	Дамдинсүрэнгийн гудамжны авто зам /Улаанбаатар/	29.8
10	Өгийнуур-Хөшөөцайдам чиглэлийн 10 км хатуу хучилттай авто зам	39.6
11	Хархорин-Цэцэрлэгийн 74 км хайрган авто замыг хатуу хучилттай болгох	91.1
12	Арайхээр-Баянхонгор чиглэлийн 23 км хайрган авто замыг хатуу хучилттай болгох	130.7
13	Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам	378.4
14	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 109 км хатуу хучилттай авто зам	531.5
15	Баянуур-Дашинчилэн чиглэлийн 9 км хатуу хучилттай авто зам /Булган/	36.9
16	Хануйн голын төмөр бетон гүүр-Халзанбүргэдэй чиглэлийн 65.3 км хатуу хучилттай авто зам /Катарын тусламж/	12.1
17	Баянхонгор-Арвайхээрийн 27 км хатуу хучилттай авто зам	25.1
18	Нийслэлийн авто замын сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Нарангийн голын 3.2 км авто зам/	40.8
19	Үйлдвэрчний эвлэлийн гудамжны 1.3 км хатуу хучилттай авто зам	61.3
20	Хөвсгөл аймгийн төвийн 1.9 км хатуу хучилттай авто зам	40.6
21	Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын 1.6 км авто зам	22.2
22	Эргэн төлөгдөх нөхцлөөр баригдах авто зам	988.4
Гүүр:		262.1
23	Ховд голын 181.8 у/м төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус/	12.8
24	Эгийн голын 162.5 у/м төмөр бетон гүүр /Хөвсгөл, Түвэл/	22.6
25	Туул голын Горхийн 211 у/м төмөр бетон гүүр /Улаанбаатар/	33.6
26	Их тэнгэрийн 258 у/м төмөр бетон гүүр /Улаанбаатар/	77.2
27	Нарийний голын 325 у/м төмөр бетон гүүр /Увс, Тэс/	64.3
28	Идэрийн голын төмөр бетон гүүр /Завхан, Их Уул/	5.8
29	Турганы голын 96.9 у/м төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Сарсай/	34.0
30	Алтан голын 17.36 у/м модон гүүр /Дорнод, Халх гол/	11.8
Иргэний нисэхийн ерөнхий газар		1,483.6
31	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Говь-Алтай/	161.7
32	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Увс/	394.4
33	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Баян-өлгий/	80.5
34	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Завхан/	348.8
35	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвасыг шинэ технологиор хатуу хучилттай болгох /Хөвсгөл, Хатгал/	92.9
36	Бодит ажиглалтын систем	405.3
Барилга, хот байгуулалт		476.9
37	Аймгийн Засаг даргын Тамгын газрын конторын барилга /Завхан/	129.7
38	үерийн хамгаалалтын далан сувгийн ажил /Дархан-Уул, Дархан/	82.1
39	Цэвэр усны шугам, өргөлтийн насосны шинэчлэлт /Сэлэнгэ, Орхон-Хөтөл/	191.7
40	Бохир ус цэвэрлэх байгууламж /Говьсүмбэр, Чойр/	37.1
41	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Дундговь, Мандалговь/	36.2
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД		23.3
1	Тагнуулын хэлтсийн барилга /Завхан/	23.3
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД		244.8
1	Дундговь аймгийн Сайнцагаан сум дахь шатахуун агуулах савыг Дорноговь аймгийн Айраг суманд шилжүүлэн байршуулах	244.8
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД		684.5
1	Спорт цогцолбор, 600 суудал /Өвөрхангай/	187.8
2	Спорт цогцолбор, 450 суудал /Булган/	448.2
3	Төрөх эмнэлгийн барилга, 50 ор /Увс, Улаангом/	48.5
НИЙТ ДҮН		12,866.8

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн жагсаалт батлах тухай" Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 47 дугаар тогтоолд дор дурдсан агуулгатай 3, 4 дэх заалт нэмсүгэй:

"3. Төсвийн орлогын эх үүсвэр болон барилга байгууламжийн ажлыг ач холбогдол, хөрөнгө оруулалт, үр өгөөж, ашигт малтмалын орд газруудын дэд бүтцийн бүтээн байгуулалттай уялдуулан дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн ажлын 50 хувийг гүйцэтгэсний дараа гэрээний үнийн 50 хувийг, ашиглалтад оруулсны дараа үлдсэн 45 хувийг, баталгаат хугацаа дууссаны дараа 5 хувийг тус тус улсын төсвөөс олгох, гүйцэтгэгчид Засгийн газраас вексель, өрийн бичиг гаргах замаар

төлбөрийг баталгаажуулах зарчим баримтлахыг Засгийн газар /С.Баяр/-т зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын хавсралтад заасан авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн жагсаалтад орсон объектуудыг ач холбогдлоор нь эрэмбэлэн гүйцэтгэгчийг нь тендер шалгаруулалтаар болон шууд сонгон гүйцэтгүүлэхдээ төсөв, үнийн өсөлттэй уялдуулан хугацаа, төсөвт өртгийг нарийвчлан тооцохыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай."

2. Мөн тогтоолын 2 дахь заалтын "уг объектыг ашиглалтад хүлээж авсаны дараахь эхний жил 30 хувь, 2 дахь жил 30 хувь, 3 дахь жил 40 хувиар тус тус тооцон" гэснийг "төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаарт багтаан" гэж, 3 дахь заалтын дугаарыг "5" болгон тус тус өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойн медаль бий болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойн медаль бий болгосугай.
2. Халхын голын 1939 оны байлдааны

ялалтын 70 жилийн ойн медалийн тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, уг медалийг олгох журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

 МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 50 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХАЛХЫН ГОЛЫН 1939 ОНЫ БАЙЛДААНЫ ЯЛАЛТЫН 70 ЖИЛИЙН ОЙН МЕДАЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэг. Медалийн хэлбэр дүрс, бэлгэдэл утгын товч тайлбар

1.1. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойн медаль /цаашид "медаль" гэх/ нь зүүлт, тэмдэг гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

1.2. Медалийн зүүлт болох дээд хэсэг нь цацраг мэт доороосоо дээш бүдүүрсэн хэлбэртэй байх ба энэ нь дээшээ мандан бадрах гэсэн санааг агуулна. Дээд талын тэгш 1 мм-ийн никель хүрээ нь доошлох тусам бага зэрэг бүдүүрнэ. Дээд хэсэг нумарсан гарын алга мэт байгаа нь эх орноо энхрийлэн хайрлах гэсэн санааг агуулна.

Цагаан, цэнхэр өнгийн алслалтай дүрслэл нь түүхэн үйл явдал, он цагийн илэрхийлэл болж дурсан хүндэтгэхийн бэлгэдэл болно.

Зүүлтний улаан, цагаан, цэнхэр өнгийн хослол нь Монгол Улс, Оросын Холбооны Улсын төрийн далбааны өнгийг хамтатган үзүүлэх бөгөөд энэ нь тус 2 улсын найрамдалт харилцаа тэр үед хамт байсан шигээ үеийн үед мандан бадрахын бэлгэдэл юм. Улаан өнгө нь ялан дийлэхийн бэлгэ тэмдгийг, цагаан өнгө нь аливаа түүхэн алдаа, эндэгдлийг одоо, ирээдүйд дахин гаргахгүй, түүнийг цагаатган ойлгохыг, цэнхэр өнгө нь тунгалаг Халхын гол, энх амгалан хөх тэнгэрийг тус тус бэлгэдсэн.

1.3. Медалийн доод хэсэг болох тэмдгийг 5 талт дүрстэйгээр сонгосон нь цэрэг, армийн бэлгэдэл таван хошуу дүрсийг агуулсан ба 5 хошууны алтан шар цацрагууд нь ялалтын сүр хүч, ялгуусан их алдар гавьяаг илэрхийлэн бэлгэдэнэ.

Тэмдгийн голын бөөрөнхий дүрслэл бүхий фон нь дэлхий, нар болон эх орноо хамгаалах утгатай бамбай гэсэн бэлгэдлийг агуулна.

Бамбай дээр байрлах 70 гэсэн тоо нь Халхын голын ялалтын 70 жилийн ойн цар хүрээг тоон утгаар болон хэлбэр дүрсээр илэрхийлнэ.

Ялалтын туг барьж, илд далайсан Монгол морьт цэрэг нь "Ялалт" гэсэн бэлгэдэл бөгөөд Монгол морьт цэрэг оролцсон байлдаан байсныг харуулсан Халхын голын ялалтын илэрхийлэл юм. Алтан цацрагийг ороон сүлжсэн мэт дүрслэл бүхий төмөр эмжээрээр хүрээлэгдсэн нь ялалтын яруу алдар, сүр хүч гэсэн санааг, бичээсийг ухаж гаргасан нь энэ алдар гавьяаг мөнхлөн дээдлэх санааг давхар илэрхийлсэн ба 2 таван хошуу нь Монгол-Оросын ган бат найрамдал, хамтын ялалтын алдар гавьяаг илэрхийлнэ.

Хоёр. Медалийн хийц, хэмжээ

2.1. Зүүлт болох дээд хэсэг нь 30x25 мм-ийн хэмжээтэй доороосоо дээш бүдүүрсэн хэлбэртэй бөгөөд 1 мм-ийн мөнгөн /никель/ хүрээ нь доошлох тусмаа бүдүүрнэ. 2 талаараа улаан, дундаа цэнхэр 2 талдаа улаан зураастай. Хүрээний доторхи өнгүүд нь /тууз/ даавуун байна.

2.2. Тэмдэг болох доод хэсэг нь шар-бронзон болон никель мөнгөн өнгийн хослолтой 20 мм-ийн гольчтой, 25 мм-ийн 5 талт дүрстэй хошуу болгонд 3 хос шаргал өнгийн талст цацрагтай, тэднийг ороон сүлжсэн төмөр мэт эмжээрийн дээд талд "Халхын гол" бичээс, 2 хажууд 5 хошуу, доод талд "жил" гэсэн бичээсийг ухаж гаргасан, тэмдгийн голд дугуй дүрсэн дээр "70" гэсэн тоо байх ба дүрсийн цагариг дотор тулалдаанд орж буй илд далайсан Монгол морин цэргийн дүрсийг товойлгон хийнэ.

2.3. Зүүлт, тэмдэг хоёрыг цагаригаар холбох бөгөөд зүүлтний ар талд медалийн дугаар, медалийг тогтоох зүүтэй байна.

Монгол Улсын Их Хурлын 2009 оны
50 дугаар тогтоолын 2 дугаар хэсвэрлэлт

ХАЛХЫН ГОЛЫН 1939 ОНЫ БАЙЛДААНЫ ЯЛАЛТЫН 70 ЖИЛИЙН ОЙН МЕДАЛЬ ОЛГОХ ЖУРАМ

1. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойн медалийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгоно.

2. Дор дурдсан Монгол Улсын иргэн болон гадаадын иргэнийг шагнаж болно:

2.1. Халхын голын 1939 оны байлдаанд биечлэн оролцсон ахмад дайчин;

2.2. Халхын голын 1939 оны байлдаанд оролцсон Оросын Холбооны Улсын болон Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын ахмад дайчин;

2.3. Халхын голын 1939 оны байлдааны үеэр ар талд гарамгай гавьяа байгуулсан.

3. Уг медалиар шагнуулах тухай саналыг Ахмадын хорооны дэргэдэх Дайдн оролцогчдын

Монголын хороо, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтан гаргаж, ахмад дайчдын хувьд Халхын голын 1939 оны байлдаанд оролцсныг нотолсон баримт бичгийг, бусад хүний хувьд шагнуулах болсон үндэслэлээ тодорхойлон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

4. Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ирүүлсэн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

5. Уг медалийг түүхт Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойг тохиолдуулан нэг удаа олгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Олон нийтийн радио, телевизийн
Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дамбын Ганбатыг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр

томилсугай.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2009 оны 05 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 131

 Улаанбаатар
хот

Өвөрхангай аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Өвөрхангай аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

Арвайхээр сум		Уянга сум	
1. Дүйнхаржавын Энхсайхан - Цэцэрлэгийн		5. Дамбын Дулам - Малчин	
сахиул		6. Сангидоржийн Загарзүсэм - Гэрийн	
Баруунбаян-Улаан сум		ажилтай	
2. Жавзангийн Уртнасан - Гэрийн ажилтай		7. Сүндэвийн Лхагвасүрэн - Гэрийн ажилтай	
3. Цэдэндоржийн Цэцэгмаа - Гэрийн		Хархорин сум	
ажилтай		8. Цэвэлдоржийн Дуламсүрэн - Гэрийн	
Есөнзүйл сум		ажилтай	
4. Балхаагийн Батхишиг - Малчин		9. Надмидын Одончимэг - Гэрийн ажилтай	

"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

Арвайхээр сум		29. Дөшийн Должинжав - Гэрийн ажилтай	
1. Гомоогийн Адыа - Гэрийн ажилтай		30. Золбингийн Наранмандах - Гэрийн	
ажилтай		ажилтай	
2. Даваадамбын Ичинхорлоо - Гэрийн		Гучин-Ус сум	
ажилтай		31. Бямбадоржийн Гандолгор - Гэрийн	
3. Жуковын Наранмандах - Гэрийн ажилтай		ажилтай	
4. Самдангийн Нармандах - Гэрийн ажилтай		Есөнзүйл сум	
5. Уламбаярын Ренчиндэвш - Гэрийн ажилтай		32. Чимэдийн Болормаа - Малчин	
6. Бавуугийн Уранчимэг - Хувиараа		33. Авирмэдийн Бямбаа - Малчин	
хөдөлмөр эрхлэгч		34. Лувсангомбын Гэрэл - Малчин	
7. Цэвээндоржийн Үүрцайх - Хувиараа		35. Содномын Даваасүрэн - Малчин	
хөдөлмөр эрхлэгч		36. Нацагийн Ишханд - Малчин	
8. Жадамбаагийн Энхцэцэг - Хувиараа		37. Цэдэндоржийн Чулууншүр - Малчин	
хөдөлмөр эрхлэгч		Зүүнбаян-Улаан сум	
Баруунбаян-Улаан сум		38. Бямбацэвээний Долгорсүрэн - Гэрийн	
9. Уртнасангийн Дагвадулам - Малчин		ажилтай	
10. Гээпилгийн Мандах - Гэрийн ажилтай		39. Самдангийн Дэлгэрмаа - Гэрийн ажилтай	
Бат-Өлзий сум		40. Баасангийн Төмөрдулам - Малчин	
11. Цэндэгийн Аюушжав - Малчин		41. Донойн Цэдэвсүрэн - Малчин	
12. Данайн Долгорсүрэн - Малчин		42. Мөнхийн Цэцэгэ - Малчин	
13. Нямдовчингийн Долгорсүрэн - Малчин		Нарийнтээл сум	
14. Батжавын Дуламсүрэн - Ерөнхий		43. Юмронцоогийн Баатарбаяр - Малчин	
боловсролын сургуульд тогооч		44. Рэгээндоржийн Батдолгор - Малчин	
15. Лувсанлхамын Дуламсүрэн - Ерөнхий		45. Лхагвабаатарын Дуламсүрэн - Малчин	
боловсролын сургуульд үйлчлэгч		46. Сангидоржийн Дуламсүрэн - Малчин	
16. Шагдарын Пагамдулам - Малчин		47. Доржийн Отгонтогтох - Малчин	
17. Төмөрбаатарын Тунгалаг - Малчин		48. Довчиндагвын Отгонцэцэг - Ерөнхий	
Баян-Өндөр сум		боловсролын сургуулийн багш	
18. Пунцагдашийн Лхагвацэнд - Малчин		49. Жанчивын Сүрэнжав - Малчин	
Богд сум		50. Ренчиндоржийн Цэрэнбал - Ерөнхий	
19. Нацагдамын Бадамханд - Малчин		боловсролын сургуулийн багш	
20. Тогосын Бадарч - Малчин		Өлзийт сум	
21. Нацагдоржийн Март - Малчин		51. Даансүрэнгийн Наваантуяа - Ерөнхий	
22. Дэмчигийн Нямсүрэн - ХААН банкны		боловсролын сургуулийн багш	
тооцооны төвийн эрхлэгч		52. Баатархүүгийн Нэргүй - Малчин	
23. Иновын Уранчимэг - Малчин		53. Ойдовын Сэр-Од - Хувиараа хөдөлмөр	
24. Цэрэндэгдийн Уранчимэг - Малчин		эрхлэгч	
25. Сарайсандамбын Цэвэлмаа - Малчин		Сант сум	
Бүрд сум		54. Жигжидсүрэнгийн Бум-Аюуш - Багийн	
26. Доржпаламын Алимаа - Гэрийн ажилтай		55. Гангаагийн Гавалмаа - Сумын Засаг	
27. Ёндонгийн Байгальмаа - Гэрийн ажилтай		даргын Тамгын газарт нийгмийн ажилтан	
28. Бат-Очирын Буяндэлгэр - Малчин			

56. Чойжамцын Мөнхжаргал - Малчин
Тарагт сум
 57. Даариймаагийн Нарантуяа - Малчин
 58. Цэвээнцэндийн Оюунбилэг - Малчин
Төгрөг сум
 59. Пүрэвийн Цэрэндулам - Малчин
Уянга сум
 60. Цэдэнпилийн Бямбадолгор - Малчин
 61. Бямбадоржийн Бямбадолжин - Малчин
 62. Дашзэвгийн Долгосүрэн - Малчин
 63. Адъяацэрэнгийн Дулмаа - Малчин
 64. Дүгэрийн Оюунгэрэл - Малчин
 65. Чултэмийн Оюунгэрэл - Малчин
 66. Оюунчимэгийн Сарантуяа - Гэрийн ажилтай
 67. Дондовын Цэвэлсүрэн - Малчин
 68. Сандуйжавын Цэцэгмаа - Малчин
 69. Донидын Цээрэнчимэд - Гэрийн ажилтай

- Хайрхандулаан сум**
 70. Баатарын Нина - Малчин
 71. Цэрэнбалжирын Эрдэнэчимэг - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
Хархорин сум
 72. Баатарын Бямбасүрэн - Гэрийн ажилтай
 73. Содномын Дуламжав - Малчин
 74. Бямбадоржийн Өлзийсүрэн - Гэрийн ажилтай
 75. Равдангийн Тэгшжаргал - Малчин
 76. Адъяагийн Цэрэн-Янжин - Гэрийн ажилтай
Хужирт сум
 77. Энхбаатарын Байгалмаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
 78. Пүрэвсүрэнгийн Үүрцайх - Гэрийн ажилтай

**МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Өмнөговь аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Өмнөговь аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасулгай.

"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

Номгон сум

1. Лхамсүрэнгийн Оюунсайхан - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

2. Нанзадмаагийн Энхмаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
Ханбогд сум
 3. Сүрэнжавын Хүү - Малчин

"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

Баяндалай сум

1. Нямдоржийн Насанбат - Дунд сургуулийн багш
 2. Дамцагийн Тогоо - Наран багийн малчин
 3. Долгорын Уранцэцэг - Наран багийн малчин

15. Дулмаагийн Сумъяа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
 16. Өлзийдолгорын Уртнасан - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
 17. Будгаваагийн Дүүмаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

4. Жанчивын Чимгээ - Малчин

Булган сум

5. Тогоогийн Бизъяа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч
 6. Цагаандүүгийн Мөнхсайхан - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

- Мандал-Овоо сум**
 18. Бөөзийгийн Мөнхжаргал - Гэрийн ажилтай

Гурвантэс сум

7. Дагиймаагийн Мөнхбат - Ингэн сэвстэйн заставт үйлчлэгч
 8. Аасын Нямпагма - Гоёот багийн малчин
 9. Жамсрангийн Эрдэнэбат - Гэрийн ажилтай
Даланзадгад сум

- Номгон сум**
 19. Давгасамбын Цогмөнх - ХЦ-ийн 104 дүгээр ангийн ахлагч

10. Дийдангийн Дөш - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

- Ханбогд сум**
 20. Хүүхэний Сүрэнжаргал - Малчин
Ханхонгор сум
 21. Цэнджавын Батчимэг - Малчин
 22. Цэдэвсүрэнгийн Оюун-Ундрах - Малчин
 23. Биндэръяагийн Ууганцэцэг - Малчин
 24. Цэцэгэгийн Цэнгэлмаа - Малчин
Хүрмэн сум

11. Долгорын Дэнсмаа - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

12. Гончигийн Минж - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

13. Нямхүүгийн Отгонсүрэн - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

25. Бадарчийн Отгончимэг - Малчин
Цогт-Овоо сум
 26. Цэнджавын Алтанцэцэг - Малчин
 27. Шархүүгийн Аюурзана - Малчин
 28. Сүхээгийн Насанзаяа - Малчин

14. Лхамжавын Өлзийцэцэг - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

**МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2009 оны 05 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 133

 Улаанбаатар
хот

Сүхбаатар аймгийн харъяат зарим
эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Сүхбаатар аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:

Халзан сум	Эрдэнэцагаан сум
1. Чүлтэмийн Адъяа - 1 дүгээр багийн малчин	1. Норжмаагийн Буянцэцэг - 1 дүгээр багийн малчин

"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:

Баруун-Урт сум	15. Гомбосүрэнгийн Мөнхцэцэг - Гэрийн ажилтай
1. Балдангийн Баярмаа - Гэрийн ажилтай	16. Бирвагийн Цогзолмаа - Гэрийн ажилтай
2. Чулууны Дархи - Гэрийн ажилтай	Уулбаян сум
3. Бумаагийн Ууганбаяр - Нэгдсэн эмнэлгийн сувилагч	17. Шаравын Төмөр - Хувинараа хөдөлмөр эрхлэгч
4. Гомбожавын Туул - Гэрийн ажилтай	18. Лувсансүрэнгийн Туяа - Малчин
5. Гомбын Цагаандарь - Гэрийн ажилтай	Халзан сум
6. Жамбалсүрэнгийн Эрдэнэтуяа - Гэрийн ажилтай	19. Овоогийн Энхжаргал - Гэрийн ажилтай
Баяндэлгэр сум	Эрдэнэцагаан сум
7. Цэндийн Лхагвасүрэн - Гэрийн ажилтай	20. Жамсрангийн Байгальмаа - Гэрийн ажилтай
8. Дамдинсүрэнгийн Сарангэрэл - 3 дугаар багийн малчин	21. Хадхүүгийн Нандинцэцэг - 1 дүгээр багийн малчин
9. Цэгмидийн Эрдэнэчимэг - Баян багийн малчин	22. Нэргүйн Энхбаяр - 6 дугаар багийн малчин
Мөнххаан сум	23. Мишигийн Эрдэнэхишиг - 7 дугаар багийн малчин
10. Цэрмаагийн Дүүрэнбилэг - Гэрийн ажилтай	24. Чимэдийн Эрдэнэтуяа - 4 дүгээр багийн малчин
11. Батсүхийн Эрдэнэцэцэг - Гэрийн ажилтай	
Сүхбаатар сум	
12. Чулууны Мөнхсайхан - Гэрийн ажилтай	
13. Гочоогийн Осунсүрэн - Гэрийн ажилтай	
Түмэнцогт сум	
14. Бадарчийн Мөнхзаяа - 1 дүгээр багийн малчин	

МОНГОЛ УЛСЫН
 8. Жигжидийн Гантуяа - 4-р хороо
 9. Ганболдын Гэрэлмаа - 4-р хороо
 10. Мүнх Лхазийн - 7-р хороо
 11. Сэдэдийн Даваажав - 2-р хороо
 12. Дашзэвэгийн Мандахбаяр - 9-р хороо
 13. Дуламжавын Мигмар - 9-р хороо
 14. Дамбадоржийн Мөнхбаяр - 10-р хороо
 15. Отгонцэндийн Наранцэцэг - 4-р хороо
 16. Чимэддолгорын Нямсүрэн - 9-р хороо
 17. Маривын Нямдаваа - 13-р хороо
 18. Данзанбалжирын Оюунбаяр - 1-р хороо
 19. Дашзэвэгийн Оюунжаргал - 3-р хороо
 20. Бат-Эрдэнийн Одзаяа - 8-р хороо
 21. Дашзэвэгийн Отгонжаргал - 8-р хороо
 22. Дамбын Сумъяа - 6-р хороо
 23. Бор-Ухнын Саранхүү - 3-р хороо
 24. Дагвадоржийн Туяа - 6-р хороо
 25. Хүрэлхүүгийн Тунгалаг - 9-р хороо
 26. Маамын Уранчимэг - 8-р хороо

- | | |
|---|--|
| 27. Бадарчийн Цогзолмаа - 2-р хороо
28. Пүрэвдоржийн Цэвэлмаа - 8-р хороо
29. Амарравдангийн Цэндмаа - 9-р хороо
30. Сандуйжавын Цэнгэл - 9-р хороо
31. Доржийн Шийтэр - 9-р хороо
32. Цогбадрахын Энхцэцэг - 4-р хороо
33. Төмөрийн Наранццэг - 1-р хороо
Ес. Чингэлтэй дүүрэг
1. Даржаагийн Амгалан - 5-р хороо
2. Мантуушийн Арвижих - 10-р хороо
3. Цэрэндоржийн Алтанзаа - 11-р хороо
4. Түгдэнгийн Амаржаргал - 13-р хороо
5. Борхүүгийн Ариунзул - 15-р хороо
6. Цэсэмийн Байгалмаа - 10-р хороо
7. Батдоржийн Баярхүү - 12-р хороо
8. Пунцагийн Басбилэг - 13-р хороо
9. Готовын Базарханд - 19-р хороо
10. Балжирпунцагийн Батжаргал - 8-р хороо
11. Тойсомын Гантулга - 9-р хороо
12. Даваадоржийн Гангэрэл - 14-р хороо
13. Мөнхжаргалын Даваасүрэн - 18-р хороо
14. Лхаасүрэнгийн Дуламжав - 18-р хороо
15. Цэрэнлхамын Доржханд - 10-р хороо
16. Агваандоржийн Жаргалсайхан - 19-р | 17. Баярмагнайн Жавхланчимэг - 2-р хороо
18. Хурэнтохойн Жавзандулам - 10-р хороо
19. Цэвэгмидийн Мөнхзул - 12-р хороо
20. Журмэдийн Мөнхчимэг - 15-р хороо
21. Өлзийбаярын Мөнгөнцэцэг - 19-р хороо
22. Цэрэндоржийн Нарангэрэл - 10-р хороо
23. Заяхүүгийн Навчаа - 10-р хороо
24. Лувсаншаравын Нина - 12-р хороо
25. Дэмбэрэлийн Норжмаа - 13-р хороо
26. Пүрэвийн Оюунаа - 12-р хороо
27. Өлзийбаатарын Отгончимэг - 17-р
28. Лхүмбээгийн Оюунчимэг - 19-р хороо
29. Лувсаншаравын Оюунбилэг - 18-р хороо
30. Рэнцэнгийн Саранцэцэг - 7-р хороо
31. Жигжидсүрэнгийн Сүрэнхорлоо - 16-р
32. Нямын Тунгалаг - 14-р хороо
33. Төмөрхуягийн Хажидмаа - 15-р хороо
34. Ванчигийн Цэрэнням - 10-р хороо
35. Шардамбын Цэрэндолгор - 12-р хороо
36. Цэгмидийн Цэен-Ойдов - 13-р хороо |
|---|--|

хороо

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2009 оны 03 дугаар
сарын 18-ны өдөр**
Дугаар 73
**Улаанбаатар
хот**

Барилга захиалагчийн дүрэм батлах тухай

Барилгын тухай хуулийн 5.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Барилга захиалагчийн дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. "Барилга захиалагчийн дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээвэр,

барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД Х.БАТТУЛГА**
**Засгийн газрын 2009 оны 73 дугаар
тогтоолын хавсралт**

БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь барилга байгууламж барих, засварлах, шинэчлэх, өргөтгөх ажлыг (цаашид "барилгын ажил" гэж) гүйцэтгэх нөхцөлийг зохиох ёсоор бүрдүүлж эхлүүлэх, гүйцэтгэх явцад батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах, материал, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг оновчтой зохион байгуулах, барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтад оруулахтай холбоотой барилга захиалагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2. Захиалагч нь үйл ажиллагаандаа Иргэний хууль, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгож, барилгын зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвхөн үйлчилгээ үзүүлэх дүрэм болон энэхүү дүрмийг мөрдөнө.

1.3. Энэхүү дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажлын үе шат, гүйцэтгэлд хяналт тавих, тухайн барилгыг хүлээн авах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий барилга захиалагч өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дагаж мөрдөнө.

Хоёр. Барилга захиалагчийн төрөл, зохион байгуулалт

2.1. Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон тусгай зориулалтын барилга байгууламж, улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр барихаар төлөвлөсөн барилгын захиалагчийг Засгийн газар, эсвэл барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгуулалтын шийдвэрээр томилоно.

2.2. Барилга байгууламжийг өөрийн санхүүжилтээр барьж байгаа иргэн, хуулийн этгээд нь гэрээний үндсэн дээр мэргэжлийн хүн, хуулийн этгээдээр барилга захиалгын ажлыг гүйцэтгүүлж болно.



2.3. Барилга захиалагч нь тухайн барилгын гүйцэтгэгч байхыг хориглоно.

2.4. Барилга захиалагч нь байнгын ажиллагаатай эхсүл тухайн барилгын төслийг хэрэгжүүлэх хугацаагаар түр томилгодон ажиллаж болно.

2.5. Захиалагчийн бүтэц, орон тоог хөрөнгө оруулагч батлах бөгөөд захиалагчийн удирдлага нь зураг төсөл, барилгын ажил дээр 5-аас доошгүй жил ажилласан, барилгын салбарын инженер, архитектор мэргэжилтэй, мэргэжлийн зэрэг бүхий иргэн байвал зохино.

2.6. Захиалагч нь барилгын салбарт зөвлөх үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд, хувь хүн байж болно.

2.7. Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт тусгагдсан техникийн хяналтын ажлын зардлын тодорхой хэсэг болон хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад орлогоос бүрдэнэ.

2.8. Барилга захиалагч хуулийн этгээд нь өөрийн харилцах данс, тэмдэг, албан бичгийг хэвлэмэл хуудастай байж болно.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг, үйл ажиллагаа

3.1. Захиалагч нь Иргэний хууль, Барилгын тухай хуульд зааснаас гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

3.1.1. зургийн техникийн даалгавраас зөрүүтэй боловсруулсан зураг төсөл болон техникийн хүчин чадал, технологийн шаардлагыг хангаагүй бүрэн бус тоног төхөөрөмж, машин механизм, материалыг хүлээн авахаас татгалзах;

3.1.2. барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, барилгын ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, холбогдох бусад баримт бичгийг гүйцэтгэгчээс гаргуулан авах, түүнийг баталгаажуулах;

3.1.3. барилгын ажилд давшилтат хийц, шинэ материалыг нэвтрүүлэх тохиолдолд зураг төсөл боловсруулсан зохиогчоос зөвшөөрлийг авч, зохих журмаар шинжилгээ, туршилт, магадлалд хамруулан, чанар, стандартын албан ёсны баталгаажилт хийлгэн, бат бэх, тогтворжилт, найдваржилтын шаардлагыг хангуулж, үндсэн бүтээцийг өөрчлөхгүйгээр шийдвэрлэх;

3.1.4. гүйцэтгэгч нь барилга байгууламжийн үе шатны ажлыг гүйцэтгэх явцад зураг төсөл, барилгын норм, дүрэм, техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэчийн зардалаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх арга хэмжээ авах;

3.1.5. захиалагчийн эрх өөр хүн, хуулийн этгээдэд шилжсэн тохиолдолд шилжүүлсэн баримт бичгүүдийг хувийн хэрэгт хавсаргах;

3.1.6. мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгуулах;

3.1.7. барилгын ажлын үе шат бүрт зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх;

3.1.8. барилга байгууламжийн үндсэн ажилд хэрэглэсэн материал, бүтээцийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторид нууцалсан дугаар бүхий дээж өгч тодорхойлуулан ил, далд ажлыг баталгаажуулах.

3.2. Энэ дүрмийн 2.1-д заасан барилга захиалагч нь мөн дүрмийн 3.1-д зааснаас гадна дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

3.2.1. зураг төслөөр дамжуулан барилгын үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи, материал, бүтээцийг нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх;

3.2.2. барилга байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга, зүгшрүүлэлт, түүн дээр ажиллах мэргэжлийн ажилчин, мэргэжилтнийг сургаж, дадлагажуулах, бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах;

3.2.3. тухайн жилд болон дараагийн жилд баригдах барилга байгууламжийн барилгын материалын хэрэгцээг тооцож гаргах;

3.2.4. барилгын ажлын гүйцэтгэлийн мэдээг улирал тутамд гаргаж барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны болон холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.2.5. орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн хот байгуулалт, барилга захиалагчийн албаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

3.2.6. барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбарын яам болон аймаг, нийслэлийн захиалагчийг мэргэжлийн удирдлагаар хангаж, мэдээ, тайлан гаргуулан авах;

3.2.7. гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, хариуцлага тооцож ажиллах.

Дөрөв. Барилга захиалагчийн хариуцлага

4.1. Барилга захиалагч нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн, энэхүү дүрэмд заасан эрхээ хэтрүүлсэн, гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй, түүнчлэн захиалагчийн буруутай үйл ажиллагаа нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон, бусдад гэм хор, хохирол учруулсан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлах тухай

Барилгын тухай хуулийн 5.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог хавсралт ёсоор баталсугай.



2. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд

Д.Зоригт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД Х.БАТТУЛГА**

**Засгийн газрын 2009 оны 74 дугаар
тогтоолын хавсралт**

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зам, тээвэр, барилга, эрчим хүч, харилцаа холбооны барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо (цаашид бичгийг бичгийн тогтолцоо гэх)-ны зорилго, зарчим, бүтцийг тогтоож, норматив баримт бичигт тавигдах шаардлага, тэдгээрийн агуулга, боловсруулах, баталгаажуулах, хэрэглэх үйл ажиллагааг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.

1.2. Байгууллага, аж ахуйн нэгж нь өмчийн хэлбэрээс үл хамааран зам, тээвэр, барилга, эрчим хүч, харилцаа холбооны (цаашид салбар гэх) барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулахдаа энэхүү тогтолцоо мөрдөнө.

1.3. Баримт бичгийн тогтолцооны зорилго нь иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ашиглалтын болон барилга угсралтын зардал багатай бат бэх барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах норм, нормативын баримт бичгийн стандартчилал, нормчлолын үндсэн чиглэл, бүрдлийг тогтооход оршино.

Хоёр. Баримт бичгийн тогтолцооны зарчим

2.1. Баримт бичгийн тогтолцоо нь дараахь зарчимд үндэслэнэ:

2.1.1. шинжлэх ухаан, техникийн үндэслэл, сорилт туршилтын арга зүйд тулгуурлан боловсруулж, цаашид хөгжүүлэх асуудлыг нээлттэй байлгах;

2.1.2. Монгол Улсын хууль тогтоомжид бүрэн нийцсэн байх;

2.1.3. заавал биелүүлэх шаардлагын тоог багасгаж зөвлөмжийн шинжтэй норматив баримт бичгийн зэлэх хувийн хинг ихэсгэх замаар аж ахуйн нэгж, мэргэжилтний санаачилгыг хөгжүүлэх, бие даасан байдлыг дээшлүүлэх;

2.1.4. олон улсын стандарттай нийцүүлэх, Монгол Улсын стандартчиллын болон Олон улсын стандартчиллын байгууллагаас (ISO) гаргасан зарчмыг баримтлах;

Гурав. Баримт бичгийн тогтолцооны бүтэц

3.1. Баримт бичгийн тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна:

3.1.1. Зохион байгуулалт, арга зүйн норматив баримт бичиг;

3.1.2. ерөнхий техникийн норматив баримт бичиг;

3.1.3. хот байгуулалт, барилга байгууламжийн норматив баримт бичиг;

3.1.4. барилга байгууламжийн инженерийн тоног төхөөрөмж ба гадна сүлжээний норматив баримт бичиг;

3.1.5. барилгын бүтээц ба эдлэхүүний норматив баримт бичиг;

3.1.6. барилгын материал ба эдлэхүүний норматив баримт бичиг;

3.1.7. зөөврийн барилга байгууламж, барилгын тоноглол эд хэрэгсэл ба багажийн норматив баримт бичиг;

3.1.8. эдийн засгийн норматив баримт бичиг.

3.2. Норматив баримт бичиг нь энэхүү тогтолцооны 1 дүгээр хавсралтаар баталсан бүрдэлтэй байна.

Дөрөв. Норматив баримт бичигт тавигдах шаардлага

4.1. Барилгын бүтээгдэхүүн нь иргэдийн ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бий болгоход нийцсэн байх;

4.2. Барилгын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх болон барилга байгууламжийн ашиглалтын ажиллагаа нь хүний амьс, эрүүл мэндэд аюулгүй байх;

4.3. Онцгой болон гамшгийн нөхцөл байдал гэнэт үүсэх шалтгааныг урьдчилан тооцох замаар барилгын бүтээгдэхүүн болон хүн амыг эрсдэлээс хамгаалах;

4.4. Барилга байгууламжийн инженерийн тоног төхөөрөмж, барилгын бүтээц, буурь хөрсний чанар, найдвартай байдлыг хангах;

4.5. Байгалийн нөөц, баялаг, материал, түүхий эд, түлш эрчим хүч, хөдөлмөрийн нөөцийг зүй зохистой ашиглахын хамт хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагыг хангах;

4.6. Салбарын барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг (цаашид норматив баримт бичиг гэх)-ийг шинжлэх ухаан техник, технологийн орчин үеийн ололт, зураг төсөл, барилгын ажил, барилгын материалын үйлдвэрлэлийн талаархи гадаад, дотоодын туршлагад тулгуурлан, олон улсын болон техникийн талаар өндөр хөгжилтэй орнуудын үндэсний стандартыг мөрдлөг болгож боловсруулсан байх;

4.7. Нормативын баримт бичигт барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг тусгасан байх.

Тав. Норматив баримт бичгийн агуулга

5.1. Нийтээр дагаж мөрдөх норматив баримт бичгийг улсын чанартай баримт бичиг, үйлдвэр-салбарын баримт бичиг гэж хоёр ангилна.

5.1.1. Улсын чанартай баримт бичигт дараахь баримт бичиг хамаарна:

-Монгол Улсын барилгын норм ба дүрэм БНБД;

-Монгол Улсын барилгын үндэсний стандарт

MNS;

-Зураг төсөл, барилгын ажил, барилгын материалын үйлдвэрлэлийн барилгын дүрэм БД;

-Тогтолцооны удирдлагын чанартай баримт бичиг УББ.

5.1.2. Үйлдвэр-салбарын норматив баримт бичигт байгууллага, аж ахуйн нэгжийн стандарт хамаарна. БСТ

5.2. Монгол Улсын барилгын норм ба дүрэм нь хот суурин газар, барилга байгууламж, инженерийн тоног төхөөрөмжийн зураг төсөл зохиох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, барьж байгуулахад хүрэх түвшин, зорилтыг тодорхойлсон заавал биелүүлэх шаардлагыг тогтооно.

5.3. Монгол Улсын барилгын үндэсний стандарт нь барилга байгууламжийн хэсгийн үзүүлэлт, шинж чанар, барилгын материал, эдлэлийг боловсруулах, үйлдвэрлэх болон ашиглалтын үеийн техникийн бодлогын нэгдлийг хангахын тулд заавал биелүүлэх болон зөвлөмжийн шинжтэй журмыг тогтооно.

5.4. Зураг төсөл, барилгын ажил, барилгын материалын үйлдвэрлэлийн барилгын дүрэм нь барилгын норм, дүрэм болон стандартын заавал мөрдөх шаардлагыг хангах, хөгжүүлэхэд чиглэгдсэн зөвлөмжийн шинж чанартай байна.

5.5. Тогтолцооны удирдлагын чанартай баримт бичиг нь салбарын барилга байгууламжийн норматив баримт бичигт хэрэглэх, боловсруулах үйл ажиллагааны зохион байгуулалт-арга зүйг тогтоосон заавал биелүүлэх болон зөвлөмжийн шинжтэй байна.

5.6. Норматив баримт бичиг нь салбарт тавигдаж байгаа зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн, техник, эдийн засгийн үндэслэлтэй заалтыг агуулсан байна.

5.7. Норматив баримт бичигт Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулах асуудлыг тусгаж болохгүй.

5.8. Норматив баримт бичиг нь заавал биелүүлэх болон зөвлөмжийн шинжтэй заалтыг агуулна.

5.9. Заавал биелүүлэх заалт нь шаардлагын хамгийн доод буюу зөвшөөрөгдөх хамгийн дээд түвшинг тогтооно.

5.10. Зөвлөмжийн шинжтэй заалтад хэрэглэгчийн тодорхой хэрэглээ, боломж, үйлдвэрлэлийн нөхцөлөөс хамааран өөрчлөгдөж болох норм, дүрмийн илэрхийллүүд хамаарна.

5.11. Норматив баримт бичгийн оршил хэсэгт заавал биелүүлэх болон зөвлөмжийн шинжтэй заалтыг тодорхойлсон байна.

5.12. Барилгын норм ба дүрэмд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд цаг уур, инженер геологийн болон бусад онцлог шинж чанарыг харгалзан нийтлэг мөрдөх, заавал биелүүлэх заалтыг тогтоох бөгөөд дараахь шаардлагыг агуулсан байна:

5.12.1. Барилга байгууламж, түүний системийн ашиглалтын найдвартай байдал, барилга бүтээц ба суурийн бат бэх тогтвортой чанар;

5.12.2. Газар хөдлөлт, хөрсний нуралт, гулсалт болон байгалийн бусад аюул ослын үед барилга, байгууламжийн тогтворжилт, хүмүүсийн аюулгүй байдлыг хангах чанар;

5.12.3. Гал түймрийн болон аюул ослын үед барилга байгууламжийн тогтворжилт, хүмүүсийн аюулгүй байдлыг хангах чанар;

5.12.4. Барилга байгууламжийн ашиглалтын үеийн өрөө тасалгааны дулаан, агаарын чийгшилт, дуу чимээ, гэрэлтүүлийн хэмжээ;

5.12.5. Барилга байгууламжийн ашиглалтын үзүүлэлт, параметрийг эрүүл ахуй, байгаль орчны нормтой уялдуулсан байдал;

5.12.6. Барилга байгууламжийн дулааны алдагдлыг бууруулах, түлш, эрчим хүчний зарцуулалтыг багасгасан байдал;

5.12.7. зайлшгүй шаардлагатай тохиолдолд эрүүл ахуй, байгаль орчны болон бусад норматив шаардлагаас иш татан заасан байдал;

5.13. Үндэсний стандартад тэдгээрийн төлөөс хамааруулан заавал биелүүлэх болон зөвлөмжийн чанартай заалтыг тогтоох бөгөөд дараахь шаардлагыг агуулсан байна:

5.13.1. зураг төсөл, технологийн болон бусад төрлийн норматив баримт бичигт тавигдах шаардлага;

5.13.2. барилгын зориулалт ба хэмжээний хувьд харилцан уялдах болон ижилтгэх, төрөлжих чадварт тавих шаардлага;

5.13.3. барилга байгууламжийн өрөө, тасалгаа, бүтээц, хэсгүүдийн болон инженерийн системийн элементүүдийг хянах шалгуур үзүүлэлт, гол шинж;

5.13.4. барилга, барилгын материалын үйлдвэрээс гаргаж байгаа нэгэн төрлийн бүтээгдэхүүн, тодорхой нэр төрлийн олон тоогоор үйлдвэрлэдэг барилгын материал эдлэл, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага;

5.13.5. барилгын ажил, барилгын эдлэхүүн, материал, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага;

5.13.6. барилгын ажил, барилгын эдлэхүүн, материал, тоног төхөөрөмжийг хүлээн авах дүрэм, шалгах турших аргууд;

5.14. Барилгын дүрэм нь барилгын норм ба дүрэм, үндэсний стандартын заавал биелүүлэх нөхцөл, шаардлагыг хангах, боловсронгуй болгоход чиглэгдсэн зөвлөмжийн шинжтэй журмыг тогтоох бөгөөд дараахь төрөлтэй байна:

5.14.1. барилгын инженер-хайгуул хийх, зураг төсөл боловсруулах, барилга барих болон барилга байгууламжийн ашиглалтын үед дэх зохион байгуулалт, технологи, үйлдвэрлэлийн дүрэм, журам;

5.14.2. хот байгуулалт, барилгын төрөлжилт, хэв шинжийг агуулсан норматив баримт бичиг;

5.14.3. барилга байгууламж, тэдгээрийн бүрдэл хэсгүүдийн эзэлхүүн төлөвлөлтийн болон бүтээцийн шийдэл;

5.14.4. барилгын бүтээц, суурийг тооцоолох, зураг төсгийг боловсруулах арга;

5.15. барилгын бүтээгдэхүүнийг бэлтгэх, шалгах, хүлээн авах ба нийлүүлэхэд тавих нөхцөлийг техникийн шаардлагаар тогтоож өгнө. Техникийн шаардлагын бүрдэл, агуулга, бүтэц, боловсруулах, баталгаажуулах ажиллагааг Монгол Улсын стандарт-чиллын тогтолцооны дагуу гүйцэтгэнэ.

5.16. Норматив баримт бичгийн агуулга, бүтэц, найруулга зүй, боловсруулах, баталгаажуулах ажиллагааг MNS1-1:2006, MNS1-2:2006-гаар тогтоогдсон дараахь шаардлагын дагуу гүйцэтгэнэ:

5.16.1. Барилгын норм ба дүрэм, барилгын дүрэм, удирдлагын чанартай баримт бичгийн нүүр хуудсыг энэхүү тогтолцооны 2 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу, эхний хуудсыг 3 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу боловсруулна;

5.16.2. нормативын ишлэл, хэрэглэсэн нэр томъёоны тайлбарын хэмжээ хэт их байвал тэдгээрийг баримт бичигт хавсралтаар оруулж болно;

5.16.3. норматив баримт бичгийг А4-ийн цаасан дээр хэвлэнэ.

5.17. Барилгын норм ба дүрэм, барилгын дүрэм, удирдлагын чанартай баримт бичигт "БН6Д", "БД", "УББ" гэсэн индекс тэмдэглэгээ хийж БН6Д-ийн дэс дугаарыг 01 дугаараас, БД-ийн дэс дугаарыг 101 дугаараас, УББ-ийн дэс дугаарыг 201 дугаараас тус тус эхлэнэ.

Зургаа. Норматив баримт бичгийг боловсруулах

6.1. Норматив баримт бичгийг зураг төсөл, эрдэм шинжилгээний ажлын дадлага, туршлагатай хүн боловсруулна.

6.2. Норматив баримт бичгийн тогтолцоонд хамаарагдах барилгын норм, дүрэм, заавар, зөвлөмжийн төслийг төрийн захиргааны төв байгууллагын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн байна.

6.3. Гүйцэтгэгч байгууллага нь норматив баримт бичгийн төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн санал дүгнэлтийг тусган эцэслэн боловсруулна. Төсөлд ирүүлсэн саналыг хүлээж авах боломжгүй тохиолдолд хоёр тал хамтран судалж, шийдвэрлэнэ.

Долоо. Норматив баримт бичгийг баталгаажуулах

7.1. Ерөнхий гүйцэтгэгч нь норматив баримт бичгийн төслийн эх хувийг батлуулахаар дор дурьдсан баримт бичгийн хамт холбогдох төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

7.1.1. Норматив баримт бичгийг боловсруулсан үндэслэл, өгөгдлүүд, түүнд ашигласан бусад материал, өөр бусад орны ижил төрлийн байгууллагаас баталсан баримт бичигтэй харьцуулсан танилцуулга, тайлбар бичиг;

7.1.2. Санал авахаар хүргүүлсэн норматив баримт бичгийн эхний төсөл, санал авахаар хүргүүлсэн байгууллагын жагсаалт;

7.1.3. Ирүүлсэн санал дүгнэлтийн эх хувиуд ба санал дүгнэлтийн товчоо;

7.1.4. Батлуулахаар оруулж байгаа норматив баримт бичгийн төслийн эхний нүүр хуудсанд ерөнхий гүйцэтгэгч, редактор, туслан гүйцэтгэгч байгууллагын удирдлага болон уг төслийг хянасан байгууллагын удирдах албан хаагч гарын үсэг зурсан байна;

7.1.5. Зохих шатны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн болон мэргэжлийн зөвлөлийн хурлаар тухайн баримт бичгийн төслийг хэлэлцсэн тухай хурлын тэмдэглэл;

7.1.6. Мөрдөж байгаа баримт бичигт өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох тухай шийдвэрийн төсөл;

7.1.7. Техникийн даалгаварт заасан бол норматив баримт бичгийн төслийг цахим хэлбэрээр ирүүлнэ;

7.2. Норматив баримт бичгийн төслийг батлах асуудлыг шийдвэрлэхдээ уг төсөл нь холбогдох хууль тогтоомжийн заалт, нормчлол, стандартчиллын ерөнхий зарчим, аргачлал, мөрдөж буй норм ба дүрмийн шаардлага, стандарт болон техникийн даалгавартай тохирч байгаа эсэхийг хянана.

7.3. Баримт бичгийн төслийг Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэний дараа холбогдох өөрчлөлт, тодруулгыг ерөнхий гүйцэтгэгч хийнэ.

7.4. Норматив баримт бичгийг батлахдаа түүнийг мөрдөж эхлэх хугацааг тогтоохоос гадна урьд мөрдөж байсан түүнтэй холбоотой баримт бичгийг хүчингүй болгоно.

7.5. Барилгын норм ба дүрэм (БНБД)-ийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулж хүчин төгөлдөр болгоно.

7.6. Барилгын дүрмийг (БД) боловсруулсан байгууллага нь өөрөө батлах бөгөөд түүнийг хянаж батлахын өмнө холбогдох байгууллагатай зөвшилцөж,

барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авсан байна;

7.7. Удирдлагын чанартай баримт бичгийг (УББ) барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулна.

7.8. Норматив баримт бичигт оруулах өөрчлөлтийг норматив баримт бичгийг шинээр боловсруулж, батлуулахтай нэгэн адил үе шатаар гүйцэтгэнэ.

7.9. Барилгын норм ба дүрэм, үндэсний стандарт, барилгын дүрэм, удирдлагын чанартай болон норматив баримт бичгийг хэвлэн нийтлэх ажиллагааг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зохих журмын дагуу гүйцэтгэнэ. Байгууллага, аж ахуйн нэгжийн стандарт, түүнд оруулсан өөрчлөлтийг Монгол Улсын стандартчиллын төв байгууллага бүртгэнэ.

7.10. Барилгын материал, эдлэл, хийц, бүтээц болон бусад бүтээгдэхүүнд тавигдах техникийн шаардлагыг тухайн бүтээгдэхүүний зураг төсөл, зохион бүтээх болон технологийн баримт бичгийн үндсэн хэсэг болгон үйлдвэрлэж байгууллага дараахь журмын дагуу өөрсдөө боловсруулна:

7.10.1. техникийн шаардлагыг холбогдох байгууллагатай зөвшилцөн, зохих журмын дагуу стандартчиллын төв байгууллагаар батлуулах.

7.10.2. Барилгын бүтээгдэхүүн болон барилга байгууламжийн инженерийн төхөөрөмжийн ашиглалтын үеийн үзүүлэлтэд шууд хамааралтай техникийн нөхцөлүүдийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож өгсөн бол Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж;

7.10.3. захиалагч ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд барилгыг хүлээн авахад тавигдах техникийн техникийн боловсруулж хэрэглэхээр заасан бол эдгээр төрлийн шаардлагыг зураг төслийн баримт бичгийн бүрдэлд оруулж боловсруулах;

7.11. Улсын хэмжээнд мөрдөж байгаа норматив баримт бичгийн жагсаалтыг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас жил бүр хэвлэн мэдээлж байна.

Найм. Норматив баримт бичгийг хэрэглэх

8.1. Норматив баримт бичгийн заавал мөрдөх шаардлагыг өмчийн хэлбэр, харьяаллаас үл хамааран бүх байгууллага, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн сахин биелүүлнэ.

8.2. Заавал биелүүлэх шаардлагыг агуулсан норматив баримт бичгийг холбогдох гэрээ хэлэлцээрт иш татаж тусгаагүй нь тэдгээрийг мөрдөхөөс гүйцэтгэж чөлөөлөхгүй;

8.3. Норматив баримт бичгийн зөвлөмжийн шинжтэй заалтыг гүйцэтгэгч захиалагчийн хүсэлтээр хэрэглэж болно.

8.4. Ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд зөвлөмжийн шинжтэй тодорхой заалтыг ишлэн авч тусгаан бол эдгээр заалтыг заавал биелүүлэх шаардлагад хамааруулна. Хэрэв гэрээ хэлэлцээрт зөвлөмжийн шинжтэй тусгай заалт ороогүй бол магадлалын болон техник хяналтын байгууллага уг заалтыг заавал биелүүлэх шаардлагад хамааруулж хэрэглэхийг шаардажгүй.

8.5. Ашиглагдаж байгаа барилга байгууламжийн төлөвлөлт, зохиулалт, хийц бүтээцийг өөрчлөх, шинэчлэх тохиолдолд мөрдөгдөж байгаа норматив баримт бичгийн шаардлагыг баримтлан гүйцэтгэнэ.



8.6. Ашиглагдаж байгаа барилга байгууламжийн хийц бүтээц, чанар, аюулгүй байдлын төлөвийг тогтоохдоо мөрдөгдөж байгаа норматив баримт бичгийг баримтална.

Ес. Хүлээх хариуцлага

9.1. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо болон норматив баримт бичигт тогтоосон энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Барилга байгууламжийн норм, норматив баримт бичгийн ерөнхий тогтолцооны 1 дүгээр хавсралт

НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

Баримт бичгийн бүрдэл (цогцонбор)	Стандартчилал ба нормчлолын үндсэн чиглэл
1. Зохион байгуулалт, арга зүйн норматив баримт бичиг	
10. Стандартчилал, нормчлол, сертификатчилал (баталгаажуулалт)	Барилга байгууламжийн стандартчилал, нормчлол, баталгаажуулалт, сертификатчиллын ажлын зорилго, бодлого, арга зүй, зохион байгуулах ажил
11. Инженер хайгуул	Барилгын ажил, барилгын зураг төслийн өмнөх ба төслийн ажлын инженер-хайгуулын бүрдэл, ерөнхий шаардлага ба гүйцэтгэх зарчим Төслийг зөвшилцөх, экспертиз хийх ба батлах журам Хот байгуулалт ба зураг төслийн баримт бичгийн агуулга, баталгаажуулалт
12. Үйлдвэрлэл	Барилгын ажлын зохион байгуулалт, технологийн бэлтгэл, барилгын ажлын ерөнхий дүрэм, барилгын ажлын механикжуулалт, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангах ба барилгын ажлын явцад хүрээлэн буй орныг хамгаалах Дууссан барилга байгууламж, объектуудыг хүлээн авах ба чанарын шалгалт хийх Барилга байгууламжийн материал, эдлэхүүний үйлдвэрлэлийг зохион байгуулах Технологийн ба гүйцэтгэлийн баримт бичгийн төрөл, агуулга, хэлбэрүүд, түүнийг албан ёсны болгох
13. Ашиглалт	Барилгын бүтээц болон барилга байгууламжийг гал ба засварлах ажлын техникийн үйлчилгээний ерөнхий дүрэм Засвар ашиглалтын баримт бичгийн хэлбэрүүд, төрөл агуулга, түүнийг албан ёсны болгох
2. Ерөнхий техникийн норматив баримт бичиг	
20. Барилга, байгууламжийн найдвартай ажиллагааны үндэслэл	Барилга байгууламжийн материал, бүтээц, инженерийн систем, барилга байгууламжийн эдлэхүүний ба ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангах ерөнхий зарчим Барилга байгууламжийн зориулалт, ачаалал, янз бүрийн үйлчлэлийн зорголзлийн ангилал найдварын тухай ойлголт Барилга байгууламж, бүтээц, суурийн найдварт тавих норматив шаардлагыг тогтоох зарчим ба тооцоонд хэрэглэх хүчин зүйлүүд, үл зөвшөөрөгдөх хязгаарын ангилал Барилгыг хүлээн авах статистик хяналтын арга барилын үндэс
21. Галын аюулгүй байдал	Хот байгуулалт, барилгын бүтээц, эдлэхүүн төлөвлөлтийн асуудлыг шийдвэрлэх барилга байгууламжийг ангилал тэдгээрийн гал тэсвэрлэх чадвар, түймрийн аюулын зэрэглэл, галын аюулаас хамгаалах багаж хэрэгсэл, эвакуаци хийх зам, аюулгүй бус зэргийг тодорхойлох галын аюулгүй байдлыг хангах ерөнхий зарчим Барилгын бүтээц, материал эдлэхүүний гал түймэр техникийн үзүүлэлт, түүнийг тооцоолох, хянах, туршилт хийх арга
22. Геофизикийн аюултай нөлөөллөөс хамгаалах	Хүн амын аюулгүй байдал, инженерийн хамгаалалтын байгууламжийн ашиглалт, барилгын инженерийн хайгуул, хот байгуулалт, эдлэхүүн төлөвлөлт, барилгын бүтээц, барилгын техникийн арга хэмжээнд тавигдах шаардлага
23. Бичил уур амьсгал, түүний хортой нөлөөллөөс хамгаалах	Ороо тасалгааны гэрэлтүүлэг, дуу чимээ, агаарын чийглэг, дулааны дэглэмийг хангах ерөнхий зарчим Хүрээлэн байгаа орчны (байгаль цаг уурын нөхцөл, чимээ шуугиан, чичиргээ, цацраг туяа, хорт бодисын ялгаруулалт г.м) нөлөөллийн илэрхийлэл Хүмүүсийн эрүүл мэндийг эдгээр нөлөөллөөс хамгаалах тооцооны аргууд болон төлөвлөлтийн үндсэн зарчим хийгээд туршилт, шалгах арга
24. Хэмжүүрийн нийцлэл ба харилцан орлох чанар	Барилгын хэмжээсийн харилцан орлох чанар ба нийцлийг хангах ерөнхий зарчмууд: -Хэмжээсийг зохицуулах дүрэм -Геометр илэрхийллийн зөвшөөрөгдөх алдааны /хүлцлийн/ хязгаар -Тооцооны болон хэмжих нарийвчлалыг тооцоолох хэмжих шалгах арга
3. Хот байгуулалт, барилга байгууламжийн норматив баримт бичиг	
30. Хот байгуулалт	Хүн амын суурьшилт, үйлдвэрлэх хүчний байршил, хот суурин газрын хоорондын инженерийн болон тээврийн дэд бүтцийн хөгжил, нутаг дэвсгэрийн болон хэсэгчилсэн төлөвлөлт, барилгажилтын асуудлыг шийдвэрлэх үндсэн журам
31. Орон сууц, олон нийтийн болон үйлдвэрийн барилга байгууламж	Орон сууц, олон нийтийн болон үйлдвэрийн ба агууламжын барилга, байгууламжууд, тэдгээрийн бүрэлдэх хэсгийн ангилалууд хийгээд тэдгээрт тавих техникийн шаардлага Барилгын ажил, үйлчилгээ явуулах үндсэн журам, хүлээн авах дүрэм, шалгаж турших арга




32. Тээврийн байгууламж	Авто, төмөр зам, далан, агаарын, үйлдвэрлэлийн болон хотын тээврийн байгууламж түүний элементүүдэд тавих техникийн шаардлага, ачаалал ба үйлчлэл, ангилал Ажил гүйцэтгэх ба зураг төсөл боловсруулах, тооцоолох үндсэн журам, хүлээн авах дүрэм, шалгах, турших арга
33. Гидротехникийн болон усжуулалтын байгууламж	Ус хаах далан, суваг шуудуу зэргийн бэхлэгээ зэрэг барилга байгууламжид тавигдах техникийн шаардлага, ачаалал ба үйлчлэл, ангилал
34. Гол болон үйлдвэрлэлийн дамжуулах хоолой	Ажил гүйцэтгэх ба зураг төсөл боловсруулах, тооцоолох үндсэн журам, хүлээн авах дүрэм, шалгах турших аргууд Дамжуулах хоолой, нефть, нефтийн гаралтай бүтээгдэхүүний агуулах, тэдгээрийн байршилд тавигдах техникийн шаардлага
35. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтэц	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай орчинг бүрдүүлэх ерөнхий шаардлага
4. Барилга байгууламжийн инженерийн тоног төхөөрөмж ба гадна сүлжээний норматив баримт бичиг	
40. Ус хангамж, ариутгах татуурга	Гадна сүлжээ ба түүний барилга, байгууламж тэдгээрийн байршил болон дотор системд тавих техникийн шаардлага, систем ба хэрэглэгчдийн ангилал, ус хэрэглээний нормууд, ус бэлтгэх ба хаягдал усыг цэвэрлэх Ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулах болон ашиглалтын горимын үндсэн журам, эрүүл ахуй, техникийн тоног төхөөрөмж, арматур, багаж хэрэгсэл ба бохир усны хоолой дамжуулах Хүлээн авах дүрэм, шалгах, турших арга
41. Дулаан хангамж, халаалт, агаар сэлгэлт ба кондиционер (агаар сэлгэлт)	Систем ба хэрэглэгчийн ангилал, гадна сүлжээ ба барилга байгууламж тэдгээрийн байршил, төхөөрөмж дотор системд тавих техникийн шаардлага Дулааны хэрэглээний норм, хаягдлыг цэвэрлэх, хоёрдогч дулааны нөөцийг ашиглах норм Ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулах, ашиглалтын горимын үндсэн журам Халаалтын хэрэгсэл, арматур, агаар дамжуулах хоолой Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
42. Хий хангамж	Системийн ангилал, хий дамжуулах, тоног төхөөрөмж ба таслан хаах төхөөрөмжид тавих техникийн шаардлага Хий хэрэглээний норм Ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулах, ашиглалтын горимын үндсэн журам Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
43. Цахилгаан хангамж	Системийн ангилал, цахилгаан дамжуулах сүлжээ ба таслах төхөөрөмжид тавих техникийн шаардлага Цахилгаан хэрэглээний норм Ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулах, ашиглалтын горимын үндсэн журам Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
5. Барилгын бүтээц ба эдлэхүүний норматив баримт бичиг	
50. Барилга, байгууламжийн буурь ба суурь	Тайлбар: Барилгын бусад инженерийн системийн тоног төхөөрөмжид тавих шаардлагыг улсын тухайн стандартын шаардлагын дагуу авна. Цахилгаан тоноглол төхөөрөмжийг суориулахдаа эрчим хүчний техник хяналтын улсын болон бусад байгууллагын холбогдох норматив баримт бичгийг баримтална
51. Чулуун ба армочулуун бүтээц	Хөрсний ангилал ба тооцооны илэрхийлэл. Буурь ба гадсан суурийн зураг төсөл боловсруулах, тооцоолох Ажил гүйцэтгэх, ашиглах горим ба оношлох үндсэн журам Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга Барилга, байгууламжийн чулуун ба армочулуун бүтээцэд тавих ерөнхий шаардлага Зураг төсөл боловсруулах, тооцох аргууд ба бүтээцийн ажлыг гүйцэтгэх, ашиглах горим, оношлох журам Хүлээн авах ба шалгах, турших арга
52. Төмөр бетон ба бетон хийц	Цутгамал, угсармал болон угсармал-цутгамал бетон ба төмөр бетон бүтээцийн шаардлага Бүтээцийг барьж байгуулах, гүйцэтгэх, зэрэглээс хамгаалах, ашиглах горим болон оношлох үндсэн журам, зураг төсөл боловсруулах, тооцоо хийх арга Үйлдвэрт бэлтгэсэн төмөр бетон ба бетон бүтээц Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
53. Төмөр бүтээц	Даацын, тусгаарлах дулаалга бүхий ган ба хөнгөн цагааны хайлшин бүтээцэд тавих ерөнхий шаардлага Бүтээцийг бэлтгэх ба угсрах, зэрэглээс хамгаалах, ашиглах горим, оношлох үндсэн журам ба зураг боловсруулах, тооцоолох арга Үйлдвэрт бэлтгэсэн ган бүтээц Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
54. Модон бүтээц	Барилга, байгууламжийн модон бүтээцэд тавих ерөнхий шаардлага, бүтээцийг бэлтгэх, угсрах, ялзралт, өгөршилтөөс хамгаалах, ашиглах горим, оношлох үндсэн журам ба зураг төсөл боловсруулах, тооцоолох арга Үйлдвэрт бэлтгэсэн модон бүтээц ба эдлэхүүн Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
55. Бусад материалаар бэлтгэсэн бүтээц	Асбестоцемент зэрэг материалаар бэлтгэсэн бүтээцэд тавих ерөнхий шаардлага Бүтээцийг бэлтгэх, угсрах, ашиглах горим, оношлох байдлын үндсэн журам, бүтээцийн зураг төсөл зохиох, тооцоолох арга Үйлдвэрт бэлтгэсэн бүтээц Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга



56. Цонх, хаалга, дааман хаалга ба тэдгээрийн хэрэгсэл	Эдлэхүүнд тавих ерөнхий шаардлага Эдлэхүүний ба түүний иж бүрдүүлэх эд ангийн техникийн нөхцөл Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
6. Барилгын материал ба эдлэхүүний норматив баримт бичиг	
60. Ханьн өргийн материалууд	Тоосго ба ханьн янз бүрийн чулуун материалд тавих ерөнхий шаардлага Тодорхой зүйл материал, маяг загвар, маркийн техникийн нөхцөл Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
61. Эрдэст барьцалдуулах бодис	Цемент ба бусад барьцалдуулах бодист тавих ерөнхий шаардлага Тодорхой зүйл материал, маяг загвар, маркийн техникийн нөхцөл Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
62. Бетон ба зуурмаг	Янз бүрийн төрлийн бетон, бетон хольц, барилгын зуурмагт тавих ерөнхий шаардлага. Тухайн төрөл зүйлийн техникийн нөхцөл. Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга.
63. Дайрга, хайрга, барилгын элс	Дайрга, хайрга, элс, зохиомол ба байгалийн сүвэрхэг дүүргэгчид тавих ерөнхий шаардлага Эдгээр материалуудын тодорхой төрлүүдийн техникийн нөхцөл Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
64. Дулаан, дуу тусгаарлах болон дуу шингээх материал	Эрдэс хөвөн эдлэхүүн, сүвэрхэг бетон эдлэхүүн, хөөлт цийдмэгээр бэлтгэсэн хавтган ба бусад дулаан тусгаарлах материалд тавих ерөнхий шаардлага Эдгээр материалын техникийн нөхцөл Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
65. Дээврийн, ус тусгаарлалтын ба бин битүүмжйн материал ба эдлэхүүн	Дээврийн хуйлмал материал, дээврийн лавмаг, тусгаарлалтын ба бин битүүмжүүлэх материалд тавих ерөнхий шаардлага Эдгээр материалын техникийн нөхцөлүүд Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
66. Засал, чимэглэл, өнгөлгөөний материал	Полимер, керамик, модон бусад заслал чимэглэлийн ба өнгөлгөөний материал, эдлэхүүнд тавих техникийн шаардлага Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
67. Асбесто-цементэн (шөрмөсөн) эдлэхүүн	Асбесто-цементэн хавтгай ба долгионт хуудас, яндан хоолой, шахмал эдлэхүүнд тавих техникийн шаардлага Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
68. Замын материал	Асфальт бетон, асфальт бетоны хольц зэрэг бусад замын барилгын материалд тавих техникийн шаардлага Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
69. Барилгын шил	Хуудас шил, барилгад зориулсан шилээр хийсэн эдлэхүүнүүдэд тавих техникийн шаардлага Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
7. Зөөврийн барилга байгууламж, барилгын тоноглол эд хэрэгсэл ба багажийн норматив баримт бичиг	
70. Зөөврийн барилга байгууламж	Ангилал ба техникийн ерөнхий шаардлага Тодорхой хэв шинжийн барилга байгууламжийн техникийн нөхцөл Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
71. Барилгын байгууллагын тоноглол	Барилгын шат, дамжуурга, бетоны аклын хэв хашмал, угсралтын тоноглол ба бэхлэлт, гар багаж, багцлах хэрэглэгдэхүүн ба чингэлэгжүүлэлтийн техникийн ерөнхий шаардлага Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
72. Барилгын үйлдвэрлэлийн тусгай тоноглол	Тоноглол ба хэвд тавих техникийн ерөнхий шаардлага Хүлээн авах дүрэм ба шалгах, турших арга
8. Эдийн засгийн норматив баримт бичиг	
80. Барилгын эдийн засаг	Хөрөнгө оруулалтын төслийн үр ашгийн асуудал, гэрээний харьцаа ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохицуулах зохион байгуулалт арга зүйн журам Зураг төсөл, хайгуулын ажлын өртгийг төслийн ба төслийн өмнөх үе шатны үед үнэлэх дүрэм ба арга
81. Үнэ бүрдэл ба төсөв	Барилгын оролцогч талуудын хоорондын тооцоо, барилгын бүтээгдэхүүний чөлөөт (гэрээний) үнийн бүрдүүлэлт болон хөрөнгө оруулалтын шаардагдах хэмжээг тодорхойлоход хэрэглэх төсөв үнэлгээний норматив бааз
82. Материалын болон түлш, эрчим хүчний нөөц	Барилга байгууламж барихад шаардагдах материалын болон түлш эрчим хүчний хангамжийн нөөцийн зарцуулалтын нормативыг боловсруулж хэрэглэх дүрэм ба аргачлал
83. Хөдөлмөрийн нөөц	Барилгын бүтээгдэхүүний элементүүдийн хөдөлмөр багтаамж болон түүнчлэн цалин хөлсөнд шаардагдах хөрөнгийг тодорхойлох арга ба дүрэм

Барилга байгууламжийн норм, норматив
баримт бичгийн ерөнхий тогтолцооны
2 дугаар хавсралт

НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН НҮҮР ХУУДАСНЫ ЗАГВАР



Барилга байгууламжийн норм, норматив
баримт бичгийн ерөнхий тогтолцооны
3 дугаар хавсралт

НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ЭХНИЙ ХУУДАСНЫ ЗАГВАР

Баримт бичгийн тэмдэглэгээ

Жишээ нь: БНБД
БД
УББ

МОНГОЛ УЛСЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ХЭЛБЭР
Жишээ нь: Монгол Улсын барилгын норм ба дүрэм

НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН НЭРИЙГ МОНГОЛ ХЭЛ ДЭЭР

НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН НЭРИЙГ АНГЛИ ХЭЛ ДЭЭР БИЧНЭ

Мөрдөж эхлэх он, сар, өдөр
Жишээ нь: Энэхүү норматив
баримт бичгийг 2009 оны 03 дугаар
сарын 18-ны өдрөөс эхлэн

Бичлэг

Тусгай хэвлэл

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон-128 тоот

☎ 262420, 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 4.5